



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн үнэт цаасны хөрөнгийг төсөвлөлтийн шаардлага хангаагүй авто замын засвар шинэчлэлтийн ажилд зарцуулсан байна.



АУДИТЫН СЭДЭВ: Нийслэлд хэрэгжсэн автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн

Улаанбаатар хот

2026 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3, 14 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийслэлд хэрэгжсэн автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/42-ШТА-ГА) тайлан хавсралтаар баталгаажуулсугай.

2.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Б.Пүрэвдагва), Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга (Б.Одбаяр) нарт зөвлөсүгэй.

3.Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан Ахлах менежер (Ч.Болд)-д үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн замын хөгжлийн газарт тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1426010022

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2-2
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3-4
	Ерөнхий мэдээлэл	5-5
Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер:	А.1 Төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөсөн үү?	6-11
Ч.Болд	А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?	6-11
Гүйцэтгэлийн аудитын алба		
Аудитын менежер:	Б.2 Төсөл арга хэмжээг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	11-19
Б.Номинбаатар		
Ахлах аудитор:	Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	11-17
Б.Билэгт		
Аудитор:	Б.2.2. Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	17-20
3.Болд		
С.Алтандэлгэр		
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	В.3 Төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?	20-25
	В.3.1. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг журмын дагуу хүлээн авч, ашиглаж байна уу?	20-26
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Аудитын дүгнэлт	27-27
	Аудитын зөвлөмж	27-27
	Холбогдох байгууллагын санал	28-28
	Саналд өгсөн тайлбар	29-29
	Хавсралтууд	30-33

Товчилсон үг

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УБ	Улаанбаатар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ЗАА	Захирагчийн ажлын алба
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
НЗХГ	Нийслэлийн Замын хөгжлийн газар
ЗХУТ	Замын хөдөлгөөний удирдлагын төв
ГУББГ	Геодези, усны барилга байгууламжийн газар
УБЗЗАГ	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар
ХТСИ	Хот төлөвлөлт, судалгааны институт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуй тооцоот үйлчилгээний газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
НТХО	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
НЗС	Нийслэлийн Замын сан
НҮЦХ	Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТББ	Тендерийн баримт бичиг

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамрах хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/108 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Нийслэлд хэрэгжсэн автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ○ Төсөл арга хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх; ○ Төсөл арга хэмжээг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; ○ Төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг НЗДТГ, НХААГ, НЗХГ, УБЗЗАГ ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан Нийслэлд 2024 онд хэрэгжсэн автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой ТАХ-ний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон ТАХ-ний хэрэгжилтийг хамруулан гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал хянан удирдаж, Гүйцэтгэл нийцлийн аудит хариуцсан ахлах менежер Ч.Болд, Гүйцэтгэлийн аудитын албаны аудитын менежер Б.Номинбаатар үе шатны</p>

Аудитын явцад
үүссэн хүндрэл
бэрхшээл

хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Билэгт, аудитор З.Болд, С.Алтандэлгэр нар хийж, гүйцэтгэв.

Аудитыг 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг НЗД, НЗХГ-т хүргүүлэв.

Аудитад хамрагдагч, шалгагдагч байгууллагууд нь баримт, материалыг заасан хугацаанд үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хангаж ирүүлээгүй нь нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, нотлох баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй байсан.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэлд 2024 онд автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой нийт 743,737.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй 315,698.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 ТАХ, үүнээс Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 279,574.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ, Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 36,124.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ байна.
2. Шинээр 2024 онд хэрэгжих 428,038.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 158 ТАХ, үүнээс Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 65,051.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ, Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 72,386.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ, Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 290,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 86 ТАХ байна.

Нийслэлд 2024 онд автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой нийт 743,737.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж, тухайн онд 499,345.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталснаас 59.0 хувийг буюу 294,870.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Бүлэг 1: ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?


1.1. НИТХ-ын 2023 оны 122 дугаар тогтоолоор Нийслэлийн 2024 оны төсвийг баталж, 2024 оны 25, 88, 105, 24/32 дугаар тогтоолуудаар нийт 4 удаа өөрчлөлт оруулж, Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нэр, байршлыг тодорхойлсон 14,463.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ, ерөнхий нэршлээр тусгасан 413,575.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 багц ТАХ, нийт 428,038.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ.

1.2. Авто замын засвар, шинэчлэлтэй холбоотой 2024 онд хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө дараах баримт бичгүүдийг баримталсан байна. Үүнд:

- НИТХ-ын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 9.19 дэх зорилт,
- НЗД-ын 2021 оны А/115 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 6.3 дахь зорилт.

1.3. Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн хүрээнд шинээр хэрэгжүүлэх 413,575.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 багц ТАХ-г ерөнхий нэршлээр баталсаныг НЗД-ын 2024 оны захирамжуудаар 142 ТАХ болгон төсөвт өртөг, нэр байршлаар задалж, тусгасан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасныг зөрчсөн байна.

Дүрслэл 1. ТАХ-г ерөнхий нэрээр баталсан байдал



Дүгнэлт: Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 90.0 хувийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.

А.1.1.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох зардлын тооцоолол хийж, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлэн батлуулсан уу?

1.4. НИТХ-ын 2024 оны 24/32 дугаар тогтоолоор Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ жагсаалтын 1.1-д “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсвийн ажил”-д бөөн дүнгээр 290,600.0 сая төгрөг баталсаныг НЗД-ын дараах захирамжуудаар 86 ТАХ болгон баталжээ. Үүнд:

- НЗД-ын 2024 оны 6 дугаар 20-ны өдрийн А/730 дугаар захирамжаар 150,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ;

- НЗД-ын 2024 оны 6 дугаар 26-ны өдрийн А/783 дугаар захирамжаар 29,610.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ;
- НЗД-ын 2024 оны 7 дугаар 08-ны өдрийн А/842 дугаар захирамжаар 80,573.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ; нийт 260,183.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 65 ТАХ;
- НЗД-ын 2024 оны 8 дугаар 09-ний өдрийн А/981 дугаар захирамжаар 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ;
- НЗД-ын 2024 оны 11 дүгээр 08-ны өдрийн А/1322 дугаар захирамжаар 26,030.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 ТАХ;
- НЗД-ын 2024 оны 12 дугаар 04-ний өдрийн А/1439 дугаар захирамжаар 2,601.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ; нийт 38,632.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ.

1.5. НЗД-ын дээрх захирамжуудаар нийт 86 ТАХ-ний төсөвт өртгийг 298,815.5 сая төгрөгөөр баталсан боловч төсвийн тодотголоор захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулж, 290,600.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

1.6. НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, УБЗАА, НЗХГ нь дээрх 65 ТАХ-ний захирамжийн төсөлд магадлалаар баталгаажсан төсөвт өртгийг тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж заасныг зөрчсөн байна.

1.7. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 10 дугаар тэмдэглэлд “Зургийн автор болон төсөвчинтэй зөвшилцөөд Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй авто зам, замын байгууламжийн зурагт оруулсан өөрчлөлтөөрөө дутагдаж байгаа бордюр дээр чулуун болгож материалынх нь хийцлэлийг өөрчилж ажлыг дуусгахыг нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан)-т үүрэг болгов” гэжээ.

1.8. Дээрх шинээр хэрэгжүүлэх 65 ТАХ-ний зураг төслийг НЗХГ-аас хянахдаа 43 ТАХ-ний авто замын хашлагыг боржин чулуугаар хийх чиглэлийг өгч, баталсан байна.

Хүснэгт. 1 ТАХ-г авто замын боржин чулуун хашлага болон бетонон хашлагаар тооцсон байдал

№	ТАХ-ний нэр	Авто замын хашлага нийт урт /м/	Боржин чулуун хашлага /нэг бүрийн өртөө/	Боржин чулуун хашлага /нийт өртөө/	(төгрөг)	
					Бетонон хашлага тооцоо /нэг бүрийн өртөө/	Бетонон хашлага тооцоо /нийт өртөө/
1	Богд уулын арын авто замын засвар, шинэчлэлт. (Буган халиунаас Маршаллын гүүр)	279.7	118,200	33,060,540.0	27,000	7,551,900.0
2	Чингэлтэйн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (32-н уулзвараас Хайлаастын уулзвар)	4,017.0	116,000	465,972,000.0	27,000	108,459,000.0
3	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Гэсэр сүмийн уулзвараас Дөлгөөн нуурын уулзвар хүртэл, хойд хэсэг)	2,491.0	118,200	294,436,200.0	27,000	67,257,000.0
4	Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Хил хамгаалахын ерөнхий газрын хойд уулзвар)	1,377.4	118,200	162,808,680.0	27,000	37,189,800.0
5	Ард Аюушийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Гэмтлийн уулзвар)	820.0	118,200	96,924,000.0	27,000	22,140,000.0
6	Элчингийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Шангрилагийн уулзвараас Парисийн гудамж хүртэл)	27.0	89,000	2,403,000.0	27,000	729,000.0
7	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	4,064.0	118,200	480,364,800.0	27,000	109,728,000.0
8	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	3,770.0	118,200	445,614,000.0	27,000	101,790,000.0
9	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	6,099.4	118,200	720,949,080.0	27,000	164,683,800.0
10	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг)	11,787.9	118,200	1,393,329,780.0	27,000	318,273,300.0

11	Галд анбошотын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (32-ын уулзвараас Баянбүрдийн тойрог Чингэлтэй дүүрэг)	3,559.3	118,200	420,709,260.0	27,000	96,101,100.0
12	Цагдаагийн академийн өргөн чөлөөний авто замын засвар, шинэчлэлт (Офицеруудын ордны тойргоос Ботаникийн уулзвар)	7,683.3	118,200	908,166,060.0	27,000	207,449,100.0
13	Чингүнжавын гудамжны авто зам засвар, шинэчлэлт (Өргөө кино театрын уулзвараас 25-р эмийн сангийн уулзвар)	3,260.7	118,200	385,414,740.0	27,000	88,038,900.0
14	Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр Баянзүрх дүүрэг)	1,194.3	118,200	141,166,260.0	27,000	32,246,100.0
15	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас ТЭЦ-3-ийн уулзвар Хан-Уул дүүрэг)	5,380.0	120,000	645,600,000.0	27,000	145,260,000.0
16	Нийслэл хүрээний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас зүүн тийш И-Мартын уулзвар Хан-Уул дүүрэг)	11,701.0	128,200	1,500,068,200.0	27,000	315,927,000.0
17	Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)	6,496.5	120,000	779,580,000.0	27,000	175,405,500.0
18	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Энхтайваны гүүрнээс дунд голын гудамж, Тэмээтэй хөшөө)	3,440.0	120,000	412,800,000.0	27,000	92,880,000.0
19	Архивчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт, (Нисэхийн тойргоос нисэхийн хурдны зам)	13,250.0	128,200	1,698,650,000.0	27,000	357,750,000.0
20	Их монгол улсын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Хоум плазагаас урагш Их тэнгэрийн уулзвар хүртэл)	5,239.0	110,000	576,290,000.0	27,000	141,453,000.0
21	Зайсангийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр)	6,370.2	118,200	752,957,640.0	27,000	171,995,400.0
22	Ажилчны гудамжны авто замын засвар шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Чингисийн өргөн чөлөө)	10,245.7	118,200	1,211,041,740.0	27,000	276,633,900.0
23	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баруун 4 замаас Гэсэр сүмийн уулзвар)	2,485.0	118,200	293,727,000.0	27,000	67,095,000.0
24	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өлзий төвийн уулзвараас 100 айлын уулзвар хүртэл)	2,825.0	118,200	333,915,000.0	27,000	76,275,000.0
25	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог)	6,435.0	118,200	760,617,000.0	27,000	173,745,000.0
26	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4 зам)	1,966.1	118,200	232,393,020.0	27,000	53,084,700.0
27	Чингэлтэйн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (7-н буудлын эцсээс Дамбын пост)	2,817.8	110,000	309,958,000.0	27,000	76,080,600.0
28	Шархадны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Цайз захын уулзвараас Эрдэнэтолгойн уулзвар)	3,637.0	118,200	429,893,400.0	27,000	98,199,000.0
29	Хүннүгийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Хоум Плазагийн уулзвараас Дүнжингарав худалдааны төвийн уулзвар хүртэл)	4,005.0	118,200	473,391,000.0	27,000	108,135,000.0
30	Улаанхуарангийн авто замын засвар, шинэчлэлт. (Офицеруудын ордны тойргоос Шар хадны авто зам хүртэл)	3,626.0	118,200	428,593,200.0	27,000	97,902,000.0
31	Дандарбаатарын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Офицеруудын ордны тойргоос Цайз захын уулзвар хүртэл)	1,976.0	118,000	233,168,000.0	27,000	53,352,000.0
32	Городокийн авто замын засвар, шинэчлэлт (Налайх дүүрэг, 5 хороо, Төв замаас Городок хүртэл Налайх дүүрэг)	1,261.0	110,000	138,710,000.0	27,000	34,047,000.0
33	Хайлаастын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэл)	16,154.6	118,200	1,909,476,084.0	27,000	436,174,740.0
34	Сансарын туннелийн авто замын засвар, шинэчлэлт. (И мартын уулзвараас туннель доогуур Их тойруу хүртэл Баянзүрх дүүрэг)	1,127.0	118,200	133,211,400.0	27,000	30,429,000.0
35	Сангийн хорооны гудамжны авто замын шинэчлэл /Бөхийн өргөөний уулзвараас Натурын зам/	2,612.0	89,900	234,818,800.0	27,000	70,524,000.0
36	Халдвартын эцсийн авто замын засвар, шинэчлэлт (Намыянжугийн гудамжнаас зүүн тийш халдвартын эцэс хүртэл)	1,570.0	89,900	141,143,000.0	27,000	42,390,000.0
37	Сансарын туслах авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын шатахуун тугээх станцаас Зүүн 4 зам хүртэл зорчих хэсгийн баруун тал)	1,495.0	108,000	161,460,000.0	27,000	40,365,000.0
38	Лувсанцэвээний гудамж авто замын засвар, шинэчлэл /Энхтайвны өргөн чөлөөнөөс Кино үйлдвэр баруун талаар Доржийн гудамж хүртэл./	1,522.0	118,200	179,900,400.0	27,000	41,094,000.0
39	Энхтайвны өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (25 дугаар эмийн сангийн уулзвараас зүүн 4 замын уулзвар)	3,043.0	120,000	365,160,000.0	27,000	82,161,000.0
40	СХД, 129 дүгээр сургуулийн авто замын үргэлжлэл (Сонгионхайрхан дүүрэг)	1,029.6	118,200	121,698,720.0	27,000	27,799,200.0
41	Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Хил хамгаалах ерөнхий газрын хойд уулзвараас Цайз захын уулзвар)	3,535.2	118,200	417,860,640.0	27,000	95,450,400.0
42	Намыянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2,122.0	118,700	251,881,400.0	27,000	57,294,000.0
43	Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сүхбаатар дүүрэг)	280.0	118,200	33,096,000.0	27,000	7,560,000.0
	Нийт	178,077.7		21,112,378,044.0		4,808,098,440.0

1.9. Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд боржин чулуун хашлага ашиглахаар тооцож, төсөвлөсөн 43 ТАХ-ний хашлаганы нэгж өртгийн нийт дүн нь 21,112.3 сая төгрөг, харин бетонон хашлага ашиглахаар тооцож үзвэл дээрх ТАХ-ний хашлаганы нэгж өртгийн нийт дүн нь 4,808.0 сая төгрөг байгаа нь нэгж өртгийг дунджаар 4 дахин нэмэгдүүлж, үнэт цаасны хөрөнгөөс 16,304.3 сая төгрөгийг хэмнэх боломж байжээ.

1.10. Мөн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийг боловсруулах явцад зураг төслийн компаниас тооцоолон гаргасан ажлын тоо хэмжээг захиалагч байгууллага НЗХГ нь замын трасс дээр очиж тоо хэмжээг тулган баталгаажуулсан нотлох баримтгүй байна. Тухайлбал:

- *Ажилчны гудамжны авто замын засвар шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Чингисийн өргөн чөлөө) 6,930.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын төгсгөл хэсэг ДЦС-3 зүүн урд буюу Чингисийн өргөн чөлөөний уулзвар хүртэл 1257м2 талбай бүхий замыг зураг төсөвт тусгаагүй;*
- *Баруун үйлдвэрийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Хөсөг трейдийн уулзвараас зүүн тийш фрезерийн зүүн тал хүртэл) 1,260.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын авто замын трассын 2 замыг холбох төгсгөлд 960м2 талбайг зураг төсөвт тусгаагүй;*
- *Халдвартын эцсийн авто замын засвар, шинэчлэлт (Намьянжугийн гудамжнаас зүүн тийш Халдвартын эцэс хүртэл) 1,132.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын авто замын трасст орсон бохирын 3 худгийг зураг төсөвт тусгаагүй;*
- *Дарь-Эхийн авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын колонкийн уулзвараас Дамбадаржаагийн уулзвар хүртэл) 6,930.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шаардлагатай авто замын ус зайлуулах шугам хоолойн ажлын тоо хэмжээг зураг төсөвт тусгаагүй;*
- *22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гармын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл) 5,985.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шаардлагатай авто замын ус зайлуулах шугам хоолойн ажлын тоо хэмжээг зураг төсөвт тусгаагүй;*
- *22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гармын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл) 6,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шаардлагатай авто замын ус зайлуулах шугам хоолойн ажлын тоо хэмжээг зураг төсөвт тусгаагүй;*
- *22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл) 8,375.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шаардлагатай авто замын ус зайлуулах шугам хоолойн ажлын тоо хэмжээг зураг төсөвт тусгаагүй;*
- *22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл) 8,950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шаардлагатай авто замын ус зайлуулах шугам хоолойн ажлын тоо хэмжээг зураг төсөвт тусгаагүй байна.*

Дүгнэлт: Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ажлын тоо, хэмжээг тулган баталгаажуулсан нотлох баримтгүй, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасантай нийцүүлээгүй байна.

А.1.1.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?

1.11. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд НЗД-ын захирамжаар нийт 260,183.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 65 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан боловч 245,753.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 ТАХ-ний зураг, төсөвт магадлалыг захирамж гарсны дараа баталгаажуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹-ийг зөрчсөн байна. Хавсралт 2

1.12. Дээрх ТАХ-ээс 14,430.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-ний магадлалын ерөнхий дүгнэлт, зураг төсөв нь тухайн ондоо батлагдаагүй байна. Үүнд:

- *Дарь-Эхийн авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын колонкийн уулзвараас Дамбадаржаагийн уулзвар хүртэл Баянзүрх дүүрэг) төсөвт өртөг 6,930.0 сая төгрөг;*
- *Алтан-Овооны замын уулзвараас Найрамдлын зам хүртэлх (Сонгинохайрхан дүүрэг) төсөв өртөг 7,500.0 сая төгрөг;*

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

1.13. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжих 81,467.8 сая төгрөгийн төсөв өртөгтэй 13 ТАХ-ний магадлалын ерөнхий дүгнэлтийг дахин гаргасан байна. Үүнд:

- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл) төсөвт өртөг 5,985.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.09.06 төсөвт өртөг 6,227.4 сая төгрөг, МЕД-2 нь 2024.10.04 төсөвт өртөг 5,985.0 сая төгрөг/
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл) төсөвт өртөг 6,300.0 сая төгрөг /МЕД-1 нь 2024.09.06 төсөвт өртөг 6,558.1 сая төгрөг, МЕД-2 нь 2024.10.04 төсөвт өртөг 6,300.0 сая төгрөг/
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл) төсөвт өртөг 8,375.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.09.06 төсөвт өртөг 8,716.9 сая төгрөг, МЕД-2 нь 2024.09.25 төсөвт өртөг 8,375.0 сая төгрөг/
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг) төсөвт өртөг 8,950.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.09.06 төсөвт өртөг 9,377.3 сая төгрөг, МЕД-2 нь 2024.09.25 төсөвт өртөг 8,950.0 сая төгрөг/
- Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан) төсөвт өртөг 21,813.3 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 21,813.3 сая төгрөг, МЕД-2 нь 2024.12.25 төсөвт өртөг 15,291.6 сая төгрөг/
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баруун 4 замаас-Гэсэр сүмийн уулзвар) төсөвт өртөг 2,499.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 1,923.8 сая төгрөг, МЕД-2 нь 2024.07.25 төсөвт өртөг 2,497.7 сая төгрөг/
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өлзий төвийн уулзвараас 100 айлын уулзвар хүртэл) төсөвт өртөг 2,146.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 1,648.4 сая төгрөг, МЕД-2 нь 2024.07.25 төсөвт өртөг 2,144.9 сая төгрөг/
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог) төсөвт өртөг 3,381.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.10 төсөвт өртөг 2,382.3 сая төгрөг, МЕД-2 нь 2024.07.25 төсөвт өртөг 3,388.5 сая төгрөг/
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойрогос Зүүн 4-н зам) төсөвт өртөг 1,680.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.11 төсөвт өртөг 3,825.3 сая төгрөг, МЕД-2 нь 2024.07.25 төсөвт өртөг 1,675.3 сая төгрөг/
- Хайлаастын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэл Чингэлтэй дүүрэг) төсөвт өртөг 4,200.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 7,177.0 сая төгрөг, МЕД-2 нь 2024.08.23 төсөвт өртөг 4,200.0 сая төгрөг/
- Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт. (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл Сүхбаатар дүүрэг) төсөвт өртөг 5,218.5 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 4,877.6 сая төгрөг, МЕД-2 нь 2024.08.19 төсөвт өртөг 5,218.4 сая төгрөг/
- Гүнтийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Шаргаморьтын уулзвараас Гүнтийн даваа хүртэл Чингэлтэй дүүрэг) төсөвт өртөг 5,250.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 4,114.0 сая төгрөг, МЕД-2 нь 2024.08.20 төсөвт өртөг 5,249.9 сая төгрөг, МЕД-3 нь 2025.07.02 төсөвт өртөг 4,958.6 сая төгрөг/
- Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Хил хамгаалах ерөнхий газрын хойд уулзвараас Цайз захын уулзвар) төсөвт өртөг 5,670.0 сая төгрөг; /МЕД-1 нь 2024.07.09 төсөвт өртөг 4,165.7 сая төгрөг, МЕД-2 нь 2024.08.19 төсөвт өртөг 5,669.9 сая төгрөг/

1.14. 2024 онд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн 33,902.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ-ний гэрээг 2024 оны 08-11 дүгээр сард байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4²-т заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Хүснэгт.5 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ТАХ-ний жагсаалт (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний хугацаа	Тайлбар
	1	2	3	4	5
1	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас тэц-3-ийн уулзвар)	2024	7,800.0	2024.08.23 2024.12.01	Хашлага суурилуулах ажил хийгдсэн
2	Ажилчны гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Чингисийн өргөн чөлөө)	2024	6,930.0	2024.09.27 2024.12.31	Гэрээ байгуулсан
3	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Баруун 4 замаас- Гэсэр сүмийн уулзвар)	2024	2,499.0	2024.09.19 2024.11.20	Хашлага суурилуулах ажил хийгдсэн
4	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Өлзий төвөөс 100-н айлын уулзвар)	2024	2,146.0	2024.09.19 2024.11.20	Хашлага суурилуулах ажил хийгдэж байна
5	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог)	2024	3,381.0	2024.10.08 2024.11.20	Хашлага суурилуулах ажил хийгдэж байна

² 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

6	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4 зам)	2024	1,680.0	2024.09.16 2024.10.15	Хашлага суурилуулах ажил хийгдсэн
7	Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт. (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл)	2024	5,218.5	2024.11.06 2024.12.15	Гэрээ байгуулсан
8	Сансарын туннелийн авто замын засвар, шинэчлэлт. (И мартын уулзвараас туннель доогуур Их тойруу хүртэл)	2024	1,050.0	2024.09.03 2024.11.20	Хашлага суурилуулах ажил хийгдэж байна
9	Натурын авто замын засвар, шинэчлэлт (Дамдинсүрэнгийн гудамжнаас урагш Нарны зам хүртэл)	2024	630.0	2024.09.23 2024.11.20	Гэрээ байгуулсан
10	Сангийн хорооны гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Бөхийн өргөөний уулзвараас Натурын зам хүртэл)	2024	1,308.0	2024.09.23 2024.11.20	Хэсэгчилж хучилтын ажил болон хашлага суурилуулах ажил хийгдсэн
11	Баруун үйлдвэрийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Хөсөг трейдын уулзвараас зүүн тийш фрезерийн зүүн тал хүртэл)	2024	1,260.0	2024.10.25 2024.12.25	Гэрээ байгуулсан
Нийт			33,902.5		

Дүгнэлт: Нийслэлийн төсвийн тодотголоор үнэт цаасны эх үүсвэрээс санхүүжих авто замын засвар, шинэчлэлтийн ажлын төсвийг бөөн дүнгээр тусгаж, магадлалаар баталгаажуулахгүй 65 төсөл арга хэмжээний нэр байршил, төсөвт өртгийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталжээ.

Бүлэг 2. ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХИЙГ НЗХГ, НХААГ-Т ШИЛЖҮҮЛЖ, ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

2.1. Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөвт боржин чулуун хашлага ашиглахаар тооцсон 186,933.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2024 онд зохион байгуулсан байна.

2.2. Худалдан авах ажиллагаанд оролцсон аж ахуйн нэгжүүд тендерт санал ирүүлэхдээ авто замын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөвт боржин чулуун хашлаганы нэгж /ширхгээр/ өртгийг дунджаар 120.0 мянган төгрөгөөр тооцон ирүүлсэн байна.

2.3. Харин “Монголын чулуун бүтээгдхүүн үйлдвэрлэгчдийн үндэсний холбоо” ТББ-аас НЗХГ-т ирүүлсэн албан бичигт авто замын боржин чулуун бордюр нийлүүлэх нэгж /ширхгээр/ өртгийг 118.0 мянган төгрөгөөр тооцон ирүүлсэн байна.

2.4. Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсөвт боржин чулуун хашлага ашиглахаар тооцсон 186,933.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа дотоодын давуу эрхийг тооцохоор ТББ-т тусгасан боловч тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдээс боржин чулуун хашлаганы дотоодын давуу эрх тооцуулах саналыг ирүүлээгүй байна.

2.5. Гаалийн ерөнхий газраас авсан статистик мэдээгээр Монгол Улсад 2024 онд импортоор орж ирсэн авто замын боржин чулуун хашлаганы нэгж өртөг дунджаар 97.3-141.9 мянган төгрөг байна.

Б. 2.1.1 Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг холбогдох хуульд нийцүүлж зарласан уу?

2.6. НЗД-ын 27 удаагийн захирамжаар 2024 онд хэрэгжүүлэх авто замын засвар шинэчлэлтийн нийт 428,038.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 158 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг харьяа агентлаг, дүүргүүдийн нэгжүүд болох 10 байгууллагад шилжүүлсэн байна.

2.7. Үүнээс 360,868.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүн бүхий 130 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6. Эрх шилжүүлсэн ТАХ-ний жагсаалт

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Эрх шилжсэн байгууллага	НЗД-аас эрх шилжүүлсэн ТАХ			ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ		Тухайн ондоо амжаагүй ТАХ	
			Захирамж	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Гэрээний үнийн дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	Нийслэлийн төсөв	УБЗАА	1	1	575.6	1	569.0	-	-
		НЗХГ	1	4	15,104.2	-	-	4	15,104.2
		НХААГ	1	11	17,624.6	10	17,095.6	1	528.8
		ХТСИ	1	1	2,300.0	1	2,300.0	-	-
		УБЗЗАГ	1	1	24,335.2	1	24,335.2	-	-
		БЗД ЗДТГ	1	1	5,112.0	1	5,087.0	-	-
	Дүн		6	19	65,051.6	14	49,386.8	5	15,633.0
2	Нийслэлийн замын сан	НЗХГ	5	47	67,273.5	41	56,005.1	6	8,430.0
		НХААГ	1	1	300.0	-	-	1	300.0
		ХТСИ	1	1	500.0	1	500.0	-	-
		ЗХУТ	1	1	1,000.0	1	1,000.0	-	-
		ГУББГ	1	1	1,000.0	1	1,000.0	-	-
		БГД ЗДТГ	1	1	1,447.8	1	1,447.8	-	-
		НД ЗДТГ	1	1	865.2	1	864.7	-	-
	Дүн		11	53	72,386.5	46	60,817.6	7	8,730.0
3	Нийслэлийн үнэт цаас	НЗХГ	7	44	178,480.4	37	160,443.5	7	17,265.2
		НХААГ	1	32	79,811.1	29	60,610.7	3	17,450.0
		УБЗЗАГ	2	10	32,211.7	4	29,610.0	6	2,601.7
		-	-	-	97.0	-	-	-	97.0
	Дүн		10	86	290,600.0	70	250,664.2	16	37,413.9
	НИЙТ ДҮН		27	158	428,038.1	130	360,868.6	28	61,776.9

2.8. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд авто зам, бродюрын шинэчлэлтэй холбоотой 19 ТАХ-г хэрэгжүүлэхээр 65,051.6 сая төгрөгийг төсөвлөснөөс 14 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж, 5 ТАХ хэрэгжээгүй байна.

Хэрэгжээгүй 5 ТАХ (төсөвт өртөг 15,633.0 сая төгрөг)

- Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төслийн нэмэлт ажил (төсөвт өртөг 9,434.4 сая төгрөг);
- Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төслийн техник технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ (төсөвт өртөг 3,085.6 сая төгрөг);
- Хайлааст Дарь-Эхийг холбосон замаас хойш Сэлбэ дэд төвийн зам руу холбогдох шинэ авто зам Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо (төсөвт өртөг 2,328.6 сая төгрөг);
- Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороонд шинээр баригдах авто зам (төсөвт өртөг 528.8 сая төгрөг);
- 200 ортой 312 дугаар цэцэрлэгийн гадна шугам сүлжээг зөөж, шилжүүлэх нэмэлт ажил Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо (төсөвт өртөг 255.6 сая төгрөг).

2.9. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2024 онд авто зам, бродюрын шинэчлэлтэй холбоотой 53 ТАХ-г хэрэгжүүлэхээр 72,386.5 сая төгрөгийг төсөвлөснөөс 46 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж, 4 ТАХ-ний ХАА тухайн ондоо амжаагүй, 3 ТАХ хэрэгжээгүй байна.

Тухайн ондоо амжаагүй 4 ТАХ (төсөвт өртөг 5,730.0 сая төгрөг)

- Гадна тойруугийн авто замаас 149 дүгээр сургууль хүртэлх холбоос зам (төсөвт өртөг 1,430.0 сая төгрөг);
- Гүүр, хоолой, туннелийн засварын ажил (төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг);
- Нийтийн тээврийн тусгай эгнээний өнгө хучилт (төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг);
- Нийслэлийн Замын хөгжлийн газрын Материал шинжилгээ, туршилт, судалгааны хэлтэст шаардлагатай тоног төхөрөөмж багаж хэрэгсэл (Төсөвт өртөг 300.0 сая төгрөг).

Хэрэгжээгүй 3 ТАХ (төсөвт өртөг 3,000.0 сая төгрөг)

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчиход ээлтэй орчин бүрдүүлэх ажил (төсөвт өртөг 500.0 сая төгрөг);
- Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил (төсөвт өртөг 1,500.0 сая төгрөг);
- Магадлашгүй ажил (төсөвт өртөг 1,000.0 сая төгрөг).

2.10. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 86 ТАХ-г хэрэгжүүлэхээр 290,600.0 сая төгрөгийг төсөвлөснөөс 66 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж, 4 ТАХ-г НЗД-ын шийдвэрээр шууд гэрээ байгуулах эрх олгож, 16 ТАХ-ний ХАА тухайн ондоо амжаагүй байна.

2.11. НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/783 тоот захирамжаар 29,610.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ, 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/1064 тоот захирамжаар 24,335.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г УБЗЗАГ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр захирамжилж, ажил гүйцэтгэх гэрээг НЗХГ-тай байгуулсан байна.

Хүснэгт 7. ХАА-г зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулсан ажлууд

(сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Тайлбар
1	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	5,985.0	5,985.0	Үндэсний их баяр наадмыг тэмдэглэхтэй холбогдуулан СХД-ийн 31, 32-р хороонд байрших Сонсголонгийн уулзвараас баруун аймгууд руу салдаг уулзвар буюу хуучнаар 22-н товчооны чиглэлийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлыг НЗД-ын 2024.06.26-ны өдрийн А/783-р захирамжийн хавсралтаар баталж, УБЗЗАГ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Тус ажлыг НЗД-ын 2024.09.11-ний өдрийн А/1064-р захирамжийн хавсралтаар баталж, УБЗЗАГ ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан.
2	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	6,300.0	6,300.0	
3	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	8,375.0	8,375.0	
4	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг)	8,950.0	8,950.0	
5	Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Баянгол дүүрэг 20 дугаар хороо)	24,335.2	24,335.2	
Нийт		53,945.2	53,945.2	

2.12. “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ нь Мегатитан ХХК, Тотал инж ХХК, Эйч Ки Би интернэшнл ХХК-аар туслан гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1³-т заасныг зөрчсөн, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна.” гэсэн заалтад хамаарагдахаар байна. Тухайн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

2.13. НЗД нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг НЗХГ, НХААГ-т шилжүүлж, тендерийг батлагдсан зураг төсөвгүйгээр зарласан байна. Тухайлбал:

- НЗД-ын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/32 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар 28.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй авто замын засвар, шинэчлэлтийн 13 төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулах эрхийг НЗХГ-т;
- НЗД-ын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/730 тоот захирамжаар 150.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулах эрхийг НЗХГ-т;
- НЗД-ын 2024 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн А/842 тоот захирамжаар 80.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулах эрхийг НХААГ-т шилжүүлж, ТАХ-ний тендер сонгон шалгаруулалт зарласан байна.

2.14. НЗХГ, НХААГ худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад зарим ТАХ-ний магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь НЗД-ын захирамжаар батлагдсан төсөвт өртгөөс зөрүүтэй гарсан байна.

³ 3.1.Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

Хүснэгт 8. Төсөвт өртөг зөрүүтэй гарсан ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	Батлагдсан төсөвт өртөг	МЕД-1		МЕД-2		(сая.төг)
			Огноо	Төсөвт өртөг	Огноо	Төсөвт өртөг	
1	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	5,985.00	2024.09.06	6,227.40	2024.10.04	5,985.00	
2	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	6,300.00	2024.09.06	6,558.10	2024.10.04	6,300.00	
3	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	8,375.00	2024.09.06	8,716.90	2024.09.25	8,375.00	
4	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг)	8,950.00	2024.09.06	9,377.30	2024.09.25	8,950.00	
5	Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)	21,813.30	2024.07.09	21,813.30	2024.12.25	15,291.60	
6	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баруун 4 замаас- Гэсэр сүмийн уулзвар)	2,499.00	2024.07.09	1,923.80	2024.07.25	2,497.70	
7	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Өлзий төвийн уулзвараас 100 айлын уулзвар хүртэл/	2,146.00	2024.07.09	1,648.40	2024.07.25	2,144.90	
8	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог)	3,381.00	2024.07.10	2,382.30	2024.07.25	3,388.50	
9	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4-н зам)	1,680.00	2024.07.11	3,825.30	2024.07.25	1,675.30	
10	Хайлаастын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэл Чингэлтэй дүүрэг)	4,200.00	2024.07.09	7,177.00	2024.08.23	4,200.00	
11	Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт. (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл Сүхбаатар дүүрэг)	5,218.50	2024.07.09	4,877.60	2024.08.19	5,218.40	
12	Гүнтийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Шаргаморьтын уулзвараас Гүнтийн даваа хүртэл Чингэлтэй дүүрэг)	5,250.00	2024.07.09	4,114.00	2024.08.20 2025.07.02	5,249.90 4,958.60	
13	Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Хил хамгаалах ерөнхий газрын хойд уулзвараас Цайз захын уулзвар)	5,670.00	2024.07.09	4,165.70	2024.08.19	5,669.90	
	Нийт дүн	81,467.80	-	82,807.10	-	79,904.80	

2.15. Магадлалын ерөнхий дүгнэлтийн зөрүүгээс шалтгаалан тендер нээх хугацааг хойшлуулсан, үнэлгээний хороо нь захиалагчаас төсөвтэй холбоотой нэмэлт тодруулга хийсэн, тендерт оролцогчдод тайлбар тодруулга хүргүүлсэн зэрэг нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах хугацаанд нөлөөлсөн байна.

2.16. НЗХГ-ын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 03/1648 тоот албан бичгийн дагуу НХААГ нь НЗД-ын 2024 оны А/842 захирамжаар батлагдсан “Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 19, 26, 28, 29 дүгээр ажлуудын зураг төсөв боловсруулагдаж байгаа шалтгаанаар тендер нээх хугацааг хойшлуулсан байна.

Үүнд:

- СБД 9, 11-р хороо Алтайн гудамжнаас Галданбошигтын гудамж хүртэл 7-р хорооллын шинэ гол гудамж зам;
- СХД 32-р хороо, Хурганы зам (Эмээлтийн авто замаас шинэ цэцэрлэг хүртэл);
- Алтан-Овооны замын уулзвараас Найрамдлын зам хүртэлх;
- СХД 129 дүгээр сургуулийн авто замын үргэлжлэл (Сонгинохайрхан дүүрэг).

2.17. Зарим ТАХ-ний худалдан авах ажиллагааг 57-68 хоногоор сунгаж, тендерийн нээлтийг хойшлуулсан нь захиалагч ТАХ-ний батлагдсан зураг төсвийг хоцроож ирүүлснээс шалтгаалсан байна. Тухайлбал:

- Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Хил хамгаалах ерөнхий газрын хойд уулзвараас Цайз захын уулзвар) 5,670.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан боловч захиалагчаас батлагдсан зураг, төсөв хоцорч ирснээс шалтгаалан тендерийг 09 дүгээр сарын 04-ний өдөр нээсэн;
- Багануур дүүргийн авто замын засвар, шинэчлэлт 720.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийг 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан боловч захиалагчаас батлагдсан зураг, төсөв хоцорч ирснээс шалтгаалан тендерийг 09 дүгээр сарын 04-ний өдөр нээсэн;
- Дамбадаржаа – Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл) 5,218.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийг

2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан боловч захиалагчаас батлагдсан зураг, төсөө хоцорч ирснээс шалтгаалан тендерийг 09 дүгээр сарын 04-ний өдөр нээсэн;

- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэглэгээний 5,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 багц задарсан ажлуудын үнэлгээний хороог 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан боловч захиалагчаас техникийн тодорхойлолт, тоо хэмжээг 3 дугаар сарын 21-ний өдөр ирүүлснээс тендерийг 4 дүгээр сарын 17-ны өдөр нээсэн;
- Хотын гол болон туслах гудамж замуудын тэмдэг, хайс, тоноглолын засвар арчлалтын ажлын 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй үнэлгээний хороог 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр байгуулж, захиалагчаас техникийн тодорхойлолт, тоо хэмжээг 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдөр ирүүлснээс тендерийг 4 дүгээр сарын 22-ны өдөр нээсэн байна.

Дүгнэлт: Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хуулиудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Б.2.1.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?

2.18. НЗХГ нь Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 35,806.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТББ-ын Тендер шалгаруулалтын зааварчилгааны 19.3-т зураг төсөл боловсруулах байгууллагын тусгай зөвшөөрөл шаардсан нь Төсвийн тухай хуулийн 29.4.⁴-д заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт 9. НЗС-ийн эх үүсвэрээс батлагдсан зураг төсөвгүйгээр 2024 онд тендер зарласан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	(сая.төг)	
		Батлагдсан төсөвт өртөг	4
1	Намьянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	3,125.0	
2	Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	4,750.0	
3	Орбитын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сонгинохайрхан дүүрэг)	2,890.0	
4	Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг)	3,700.0	
5	Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Соёолжийн нүхэн гарц орчмоос Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвар чиглэл)	2,350.0	
6	Дунжингарав худалдааны төвийн урд талын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	1,690.0	
7	УБЦТС-ын баруун талын авто замын засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)	850.0	
8	Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	3,530.0	
9	Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)	1,200.0	
10	Хилчний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	820.0	
11	Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн авто замын засвар, шинэчлэлт (Сүхбаатар дүүрэг)	560.0	
12	Хатанбаатар Магсаржавын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Баянгол дүүрэг)	800.0	
13	Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвараас Өгөөмөр зах чиглэл)	1,880.0	
14	Богд уулын арын авто замын баруун хэсгийн засвар, шинэчлэлт	2,613.0	
15	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар шинэчлэлт (Дөлгөөн нуурын уулзвараас Өлзий төвийн уулзвар хүртэл)	1,248.0	
16	Хувьсгалчдын гудамжны авто замын засвар шинэчлэлт (Тасганы овооны уулзвараас Зурагтын эцэс хүртэл)	3,800.5	
	Нийт	35,806.5	

2.19. Дээрх ТАХ-г гүйцэтгэгч байгууллагууд нь захиалагчтай гэрээ байгуулахаас өмнө тухайн ажлын зураг төсвийг боловсруулж, ажил эхлэхийн өмнө ЗТХТ-өөр зураг, төсөвт магадлал хийлгэсэн нь төсөвт өртөгт өөрчлөлт орох, зөвшилцөлд хүрэхгүй байх, ТАХ-ний хэрэгжилт удаашрах зэрэг эрсдэлтэй байна.

2.20. Намьянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг) 3,125.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгч Экспресс зам ХХК-тай гэрээ байгуулснаас хойш тендерт ирүүлсэн зураг төсөвт тусгагдсан авто замын бетонон хашлагыг 29.5 сая төгрөгөөр /материалын өртгөөр/

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

гүйцэтгэхээр байсныг НЗХГ боржин чулуун хийцлэлтэй болгон өөрчлөлт оруулж, 251.9 сая төгрөгөөр /материалын өртгөөр/ магадлал хийгдсэн байна.

2.21. ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 323,602.2 сая төгрөгийн төсөвтэй 122 ТАХ-г аудитад хамруулахад үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой заавар журмыг мөрдөөгүй, санхүү, боловсон хүчин, техникийн чадавх, машин, механизм, тоног төхөөрөмж, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг харгалзаагүй, ТББ-т тусгасан шаардлага хангаагүй оролцогчдыг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан зэрэг зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Гэсэр сүмийн уулзвараас Дөлгөөн нуурын уулзвар хүртэл, хойд хэсэг) ажил, төсөвт өртөг 2,700.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан Баткубик ХХК ижил төстэй ажилд гүйцэтгэсэн талаарх шаардлагыг хангаагүй;
- Их нарангийн авто замын засвар, шинэчлэлт (Толгойтын авто замаас Улаан чулуутын хогийг цэг) ажил, төсөвт өртөг 2,566.2 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан Эко эвсэг зам ХХК ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн талаарх шаардлагыг хангаагүй;
- СХД-ийн 4, 5 дугаар хорооны далан дагасан авто замын засвар, шинэчлэлт (Толгойтын замаас далан дагаад Баянхошууны зам) ажил, төсөвт өртөг 2,541.9 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан Ди Вай Кэй Би ХХК ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн талаарх шаардлагыг хангаагүй;
- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4 зам) ажил, төсөвт өртөг 1,680.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан Неон эгээ ХХК ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн талаарх шаардлагыг хангаагүй;
- Архивчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Нисэхийн тойргоос нисэхийн хурдны зам) ажил, төсөвт өртөг 9,800.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан Мегатитан ХХК нь тухайн ТАХ-ний ажлыг гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу санхүүгийн чадавхын шаардлагыг хангаагүй;
- Галданбошготын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (32-ын уулзвараас Баянбүрдийн тойрог Чингэлтэй дүүрэг) ажил, төсөвт өртөг 3,570.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан "Мосговь" ХХК нь Геодезийн инженертэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний нэр нь тухайн төсөл арга хэмжээний нэрээс зөрүүтэй тул ТБОНӨХБАҮХАТХ-ийн /Шинэчилсэн найруулга/-ын 28-р зүйлийн 28.1.3 дахь заалтын дагуу "Мос говь" ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу шаардлагад хангасан материал ирүүлээгүй. Мөн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан НЗХГ-ын үнэлгээний хороо нь тендэрт оролцогчийг үнэн зөв, шударгаар шалгаруулаагүй;
- Нарны замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Энхтайваны гүүрнээс 10-р хорооллын уулзвар) ажил, төсөвт өртөг 9,450.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан "Баткубик" ХХК нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28-р зүйлийн 28.1.3 дахь заалт болон тендерийн баримт бичгийн ТШЗ-ын 19.1.3-д заасан ажил гүйцэтгэхэд шаардлагатай ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага, сүүлийн 3 жилд (2021, 2022, 2023) онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ажил хийсэн байх. Ижил төстэй ажилд авто замын барилга, шинэчлэлтийн ажлыг тооцно, оролцогч нь ижил төсөвтэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр нэг удаа ажилласан байх шаардлагыг хангаагүй. Мөн тендер шалгаруулалтын үнэлгээний хорооны гишүүн нь ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэг бөглөн үнэлгээний хороонд ажиллахаас татгалзсан. Үнэлгээний хороо нь 4 хүний бүрэлдэхүүнтэй 2-р хурлаа хийж, гүйцэтгэгчээр "Баткубик" ХХК-ийг сонгон шалгаруулсан. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 51.7 Үнэлгээний хорооны хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ;
- Чингүнжавын гудамжны авто зам засвар, шинэчлэлт (Өргөө кино театрын уулзвараас 25-р эмийн сангийн уулзвар) ажил, төсөвт өртөг 2,815.5 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан "Неон эгээ" ХХК нь техникийн тодорхойлолтод заасны дагуу гэрээт ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай машин механизм, техник тоног төхөөрөмжийг өөрийн болон түрээсээр гэж заасан боловч тендэрт шалгарагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолт шаардлагад нийцээгүй. ТШЗ 19.1 Техникийн чадавх болон туршлагын шаардлага: 2. Ажил гүйцэтгэхэд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл. 4. Авто гудронатор 1 ширхэг, хүчин чадал 3000л-ээс дээш өөрийн болон түрээсийн гэж заасан боловч тендэрт оролцогчийн санал болгосон Авто гудронатор нь 1900кг даац бүхий үзүүлэлттэй байх тул шаардлагад нийцэхгүй;
- Нарны замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өвөөмөр захаас Чулуун овооны тойрог) ажил, төсөвт өртөг 4,680.0 сая төгрөг, гүйцэтгэгчээр шалгарсан "Хөвчийн зам" ХХК нь тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээр татварын тодорхойлолтоо цахимаар хугацаанд нь ирүүлээгүй. ТШЗ 16.1.2 Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад бичиг баримт: "Шаардана" 1. Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Тендэрт оролцогч нь тухайн шаардлагыг хангаж, татварын тодорхойлолтоо хугацаанд нь ирүүлээгүй.

Дүгнэлт: Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй, өрсөлдөх боломжийг хангасан боловч шаардлагад нийцээгүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Б.2.2. Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

2.22. Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн зарим ТАХ-ний төсөвт өртгийн магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй байхад НЗХГ нь ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг олгосон нь батлагдсан төсөвт өртгийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдлыг бий болгожээ. Тухайлбал:

- *Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Квадровэй ХХК-ийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн ажил дууссан тухай №29/24 тоот алба бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 232/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан;*
- *Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Хан-Уул дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Баткубик ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн ажил дууссан тухай №133/2024 тоот албан бичиг ирсэн ч, тухайн ажлын төсөвт өртгийн 256/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр баталгаажсан байна.*

Б.2.2.1 Гүйцэтгэгч нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцүүлэн гэрээний хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэхэд захиалагч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?

2.23. Зарим ТАХ-ний магадлалын дүгнэлт баталгаажаагүй байхад авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, зөвшөөрөл олгосон нь “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 2.2-т “Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг хянаж, шийдвэрлэнэ.” Гэж заасныг зөрчсөн байна. Хавсралт 3

Дүгнэлт: Нийслэлийн Замын хөгжлийн газар нь зарим ТАХ-ний магадлалын дүгнэлт баталгаажаагүй байхад авто замын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг олгосон байна.

Б.2.2.2 Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журамд заасны дагуу олгосон уу?

2.24. Нийслэлд 2024 онд автозам, бродюрын шинэчлэлтэй холбоотой нийт 743,737.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 210 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж, тухайн онд 499,345.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталснаас 294,870.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

2.25. 2024 онд олгосон санхүүжилтийн дүнг эх үүсвэрээр задалбал дараах байдалтай байна. Үүнд:

- *Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 324,224.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 ТАХ-нд 96,859.8 сая төгрөг;*
- *Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 81,728.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 ТАХ-нд 69,419.8 сая төгрөг;*
- *Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 204,893.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 54 ТАХ-нд 128,591.1 сая төгрөг олгосон байна.*

2.26. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд магадлалаар баталгаажсан хяналтын төсөвгүйгээр захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, үе шатны санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.26-д “техник, технологийн хяналт” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Квадровэй ХХК-ийн 2024 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн ажил дууссан тухай №29/24 тоот албан бичиг ирсэн байхад тухайн ажлын төсөвт өртгийн 232/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан, 2024 оны 6 дугаар сарын 14-нд 2,666.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон;
- Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Хан-Уул дүүрэг/ ажлын гүйцэтгэгч Баткубик ХХК-ийн 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн ажил дууссан тухай №133/2024 тоот албан бичиг ирсэн байхад тухайн ажлын төсөвт өртгийн 256/2024 дугаартай магадлалын дүгнэлт 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр баталгаажсан, 2024 оны 6 дугаар сарын 04-нд 881.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.27. Ажлын гүйцэтгэл гаргаагүй, засвар шинэчлэлтийн ажил эхлээгүй байхад 110,290.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 ТАХ-нд 2024 онд 28,980.5 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт. 11 Урьдчилгаа санхүүжилт олгосон ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хөрөнгийн эх үүсвэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч компани	(сая.төг)	
					2024 онд олгосон санхүүжилт	Үүнээс урьдчилгаа
А	1	2	3	4	5	6
1	Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо)	НТ	24,335.2	УБЗЗАГ ОНӨААТҮГ	5,376.1	5,376.1
2	Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбан тохижилтын ажлын зураг, төсөл боловсруулах гэрээ	НТ	2,300.0	Хот Төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ	2,300.0	991.4
3	Налайх дүүргийн авто замын засвар	НЗС	500.0	Эко эвсэг зам ХХК	485.7	148.4
4	Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Соёолжийн нүхэн гарц орчмоос Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвар чиглэл)	НЗС	2,350.0	Дэд бүтэц консалт ХХК	2,224.4	170.0
5	Дүнжингарав худалдааны төвийн урд талын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	НЗС	1,690.0	Баян-Өлзийт зам ХХК	1,949.0	110.7
6	Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)	НҮЦХ	21,813.3	Билэгтзам ХХК	6,017.7	6,017.7
7	Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр)	НҮЦХ	9,464.0	Тотал-инж ХХК	8,742.8	2,669.6
8	Наадамчдын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Яармагийн гүүрнээс Нүхтийн уулзвар)	НҮЦХ	5,775.0	Заабар ХХК	5,643.1	1,710.2
9	Чингүнжавын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Өргөө кино театрын уулзвараас 25 эмийн сангийн уулзвар)	НҮЦХ	2,815.5	Неон гэгээ ХХК	942.8	800.0
10	Их нарангийн авто замын засвар, шинэчлэлт. (Толгойтын авто замаас Улаан чулуутын хогийг цэг)	НҮЦХ	2,566.2	Эко эвсэг зам ХХК	716.7	716.7
11	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	НҮЦХ	5,985.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	4,666.0	1,795.5
12	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	НҮЦХ	6,300.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	4,913.6	1,890.0
13	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	НҮЦХ	8,375.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	6,531.8	2,512.5
14	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл)	НҮЦХ	8,950.0	УБЗЗАГ ОНӨААТҮГ	6,980.5	2,685.0
15	Багануур дүүргийн авто замын засвар, шинэчлэлт	НҮЦХ	720.0	Эс эл си ти ХХК	485.5	209.2
16	Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт. (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл)	НҮЦХ	5,218.5	Сотэ кашимер ХХК	856.0	856.0
17	Халдвартын эцсийн авто замын засвар, шинэчлэлт (Намьянжугийн гудамжнаас зүүн тийш Халдвартын эцэс хүртэл)	НҮЦХ	1,132.5	Эс эл си ти ХХК	321.6	321.6
	Нийт		110,290.2		59,153.3	28,980.5

2.28. Авто замын засвар шинэчлэлтийн 5 ТАХ-д 14,259.1 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаанд үндэслэлгүй олгосон нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12.2.⁵-д заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо), гүйцэтгэгч УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 5,376.1 сая төгрөг;
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл), гүйцэтгэгч УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 1,890.0 сая төгрөг;
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл), гүйцэтгэгч УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 2,512.5 сая төгрөг;
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл), гүйцэтгэгч УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 1,795.5 сая төгрөг;
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл), гүйцэтгэгч УБЗЗАГ ОНӨААТҮГ-т 2,685.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Дээрх ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно.” гэж заасныг зөрчсөн асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

2.29. НЗХГ-ын санхүүгийн баримтад авто замын хуучин бетонон хашлагыг зөөж устгасан, бусдад шилжүүлсэн баримт байхгүй байна.

2.30. Аудитын хүрээнд 2024 онд хэрэгжүүлсэн авто замын засвар шинэчлэлтийн 4 байршилд дээж авч үзэхэд асфальт бетон нь зузааны шаардлагыг хангаж байна. Тухайлбал:

Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)



Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл Сүхбаатар дүүрэг)



⁵ урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар баталсан “Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон даатгалын маягт”-ын дагуу гаргана);

Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өлзий төвийн уулзвараас 100 айлын уулзвар хүртэл)



Хүннүгийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Хоум Плазагийн уулзвараас Дүнжингарав худалдааны төвийн уулзвар хүртэл)



Дүгнэлт: Авто замын засвар шинэчлэлтийн 5 төсөл арга хэмжээнд 14,259.1 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр олгосон байна.

Бүлэг 3. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ КОМИСС ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫГ БҮРЭН МӨРДӨӨГҮЙ БАЙНА.

В.3.1. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг журмын дагуу хүлээн авч, ашиглаж байна уу?

3.1. Төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд хөндлөнгийн буюу мэргэжлийн хяналт, шалгалтын байгууллагын төлөөллийг оролцуулаагүй байна.

3.2. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 1 дүгээр хавсралтад заасан “Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах” ажлын хэсгийн бүрэлдэхүүнд заасан холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг байлцуулах гэж заасантай нийцээгүй байна.

В.3.1.1 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс хууль, журмыг мөрдөж ажилласан уу?

3.3. Нийслэлийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд 2024 онд нийт 52 ТАХ хэрэгжиж дууссанаас 16 ТАХ-г ашиглалтад хүлээн авах комисс ажилласан байна.

3.4. Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлсэн ажлыг хүлээн авахдаа НЗХГ-ын даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” А/34 дүгээр тушаалаар баталсан бүрэлдэхүүнээр комисс ажиллуулсан нь “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх,

үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 4.3-д “Захиалагч хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Ажлын хэсэг ажиллуулах эсэх шийдвэр гаргана.” Гэж заасантай нийцэхгүй байна.

3.5. Дээрх журмын 4.4-т “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилсноос хойш ажлын 5 хоногийн дотор ашиглалтад авах объектод очиж ажиллана.” Гэж заасан боловч ажил хүлээн авах комисс талбай дээр нь очиж ажиллаагүй байна. Тухайлбал:

- “Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвараас Өгөөмөр зах чиглэл” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр хүсэлт ирж, комисс 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр ажилласан;
- “Намьнжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр хүсэлт ирж, комисс 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ажилласан;
- “УБЦТС-ын баруун талын авто замын засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр хүсэлт ирж, комисс 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ажилласан;
- “Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүсэлт ирж, комисс 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ажилласан;
- “Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Хан- Уул дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүсэлт ирж, комисс 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ажилласан;
- “Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн авто замын засвар, шинэчлэлт (Сүхбаатар дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 7 дугаар сарын 04-ний хүсэлт ирж, комисс 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр ажилласан;
- “Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)” ажил. Тус ТАХ-ний гүйцэтгэгчээс 2024 оны 6 дугаар сарын 05-ны хүсэлт ирж, комисс 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр ажилласан байна.

3.6. Зарим ТАХ-ний хувийн хэрэгт байнгын ашиглалтад хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, зарим үүрэг даалгаврын биелэлтийг тооцсон баримт, огноо байхгүй байна. Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.3-т “*стандартын дагуу баримт бичгийн бүрдэл бүрэн байх*” гэж заасантай нийцээгүй байна. Үүнд:

- “Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвараас Өгөөмөр зах чиглэл” ажил);
- “Намьнжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)” ажил/Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудас огноо байхгүй;
- Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)” ажил;
- “Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Хан- Уул дүүрэг)” ажил;
- “Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн авто замын засвар, шинэчлэлт (Сүхбаатар дүүрэг)” ажил / ажлыг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, зарим үүрэг даалгаврын биелэлтийг тооцсон баримт байхгүй/.
- “Орбитын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сонгинохайрхан дүүрэг)” ажил.

3.7. УБЦТС-ын баруун талын авто замын засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)” ажлыг ашиглалтад хүлээн авах комиссын үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангуулаагүй байхад комиссын акт гаргаж, дүгнэлтийг баталгаажуулсан байна.

Дүгнэлт: Төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс нь холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

В. 3.1.2 Хэрэгжсэн авто зам, бродюрын ашиглалт, хамгаалалт үр дүнтэй байна уу?

3.8. НЗХГ-аас авто замын засвар, шинэчлэлтийн ажилд боржин чулуун бродюр ашиглах нь хашлаганы насжилтыг уртасгаж, ашиглалтын хугацааг нэмэгдүүлнэ гэсэн тайлбарыг ирүүлсэн боловч энэ чиглэлээр хийсэн туршилт судалгааны материал байхгүй байна.

3.9. НЗХГ-ын Материал шинжилгээ, туршилт судалгааны итгэмжлэгдсэн лаборатори нь MNS 842:2006 Стандартын хүрээнд “Шахалтын бат бэх” үзүүлэлтээр авто замын хашлаганд шинжилгээ хийдэг боловч хашлаганы насжилтыг тодорхойлдоггүй байна.

3.10. Монгол улсад авто замын хашлаганд “Авто замын бетон болон төмөрбетон хашлага” MNS 0842:2006 стандарт, Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04, Улаанбаатар хотын UCS 0901B:2022 “Иж бүрэн гудамж”, UCS 1601B:2022 “Зорчигч тээврийн үйлчилгээ” стандартыг мөрдлөг болгож ажиллахаар байна.



3.11. Аудитын хүрээнд авто замын засвар, шинэчлэлтийн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь очиж үзэхэд Монгол Улсад мөрдөгдөж буй стандарт, норм ба дүрэмд заасан шаардлагыг хангаагүй дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

1. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-ийн 2.8-д “Явган хүний болон унадаг дугуйн зам нь тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн замын түвшнээс 15 см өндөр өргөгдсөн байна” гэж заасан боловч зарим байршилд явган хүний зам нь тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн замын түвшнээс 15 см өндөр өргөгдөөгүй байна.

Тухайлбал:

Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас ТЭЦ-3-ийн уулзвар Хан-Уул дүүрэг)



Зайсангийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр)



Сансарын туннелийн авто замын засвар, шинэчлэлт (И мартын уулзвараас туннель доогуур Их тойруу хүртэл Баянзүрх дүүрэг)



2. Улаанбаатар хотын UCS 0901В:2022 “Иж бүрэн гудамж” стандартын 6.7-д “Явган хүний замын гадаргуугийн өндрийн огцом өөрчлөлтийг аль болох 0 байхаар төлөвлөх хэдий ч боломжгүй тохиолдолд 6мм-ээс ихгүй байна. Өндрийн өөрчлөлтөд авто замын хашлага, одоо байгаа зам, инженерийн шугам сүлжээний худаг, худгийн таг, ус зайлуулах суваг гэх мэт зүйлс хамаарна.” гэж заасныг бүрэн мөрдөөгүй байна.

3. Улаанбаатар хотын UCS 1601В:2022 “Зорчигч тээврийн үйлчилгээ” стандартын хавсралт 4.1-д “Зорчигч автобусанд суух, буухад хялбар дөхөм байхын тулд замын хашлага нь автобусны гишгүүрийн тавцантай нэг түвшинд, зэрэгцээ байрласан байна.” Гэж заасныг бүрэн мөрдөөгүй байна. Тухайлбал:

Хайлаастын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэл Чингэлтэй дүүрэг)



Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баруун 4 замаас- Гэсэр сүмийн уулзвар)



Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог)



Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4-н зам)



3.12. Захиалагч нь хяналтыг хэрэгжүүлэхдээ “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.6-д заасныг мөрдөөгүй байна. Үүнд:

- Авто замын хашлага буюу бродюрын арын тулц, бетон, манаасыг дутуу гүйцэтгэсэн;
- Авто замын хашлага /бродюр/-ны гагнаасны ажлыг дутуу гүйцэтгэсэн.

Тухайлбал:

Их монгол улсын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Хоум плазагаас урагш Их тэнгэрийн уулзвар хүртэл)



Цагдаагийн академийн өргөн чөлөөний авто замын засвар, шинэчлэлт (Офицеруудын ордны тойргоос Ботаникийн уулзвар)



22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл, Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл, Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл, Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг)



Нарны замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Энхтайваны гүүрнээс 10-р хорооллын уулзвар)



Дарь-Эхийн авто замын засвар, шинэчлэлт (Сансарын колонкийн уулзвараас Дамбадаржаагийн уулзвар хүртэл Баянзүрх дүүрэг)



3.13. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 124,956.0 сая төгрөгийн 88 төсөл арга хэмжээг захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх хүртэл бусад эргэлтийн хөрөнгөд бүртгээгүй, НЗХГ-ын хөрөнгийн зардлаар шууд бүртгэсэн байна.

3.14 Энэ нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын 5.4.4-т “Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана”, 5.4.5-д “Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүгнэлт: Авто замын засвар шинэчлэлийн хүрээнд 2024 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь мөрдөгдөж буй стандартыг бүрэн хангахгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн төсөвт авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажлыг төлөвлөхдөө Төсвийн тухай хуульд нийцүүлээгүй, ажлын тоо, хэмжээг тулган баталгаажуулсан нотлох баримтгүй, төсөл арга хэмжээ тус бүрээр батлаагүй байна.
2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, нээлттэй, өрсөлдөх боломжийг хангасан боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
3. Нийслэлийн Замын хөгжлийн газар нь зарим ТАХ-ний магадлалын дүгнэлт баталгаажаагүй ажлыг эхлүүлж, урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр санхүүжилт олгосон байна.
4. Авто замын засвар шинэчлэлийн хүрээнд 2024 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь мөрдөгдөж буй стандартыг бүрэн хангаагүй, ашиглалтад хүлээн авах комисс нь холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
5. Аудитаар 2 байгууллагад 4 зөвлөмж хүргүүлж, 53,945.2 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:


Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажаагүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх.
2. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэхгүй, тендер шалгаруулалтыг зохион байгуулахгүй, урьдчилгаа төлбөрийн баталгаагүй санхүүжилт олгохгүй байх.

Нийслэлийн Замын хөгжлийн газарт

1. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох ажлын тоо хэмжээг тулган баталгаажуулсан нотлох баримтыг үйлдэх.
2. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахдаа холбогдох дүрэм, журам, стандартыг бүрэн хангуулж, ажиллах.

Холбогдох байгууллагын санал



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
 Нийслэлчин аяа 1200, Аудитын өм, 25 дугаар хороо, 3-ын 7-ий дугаар, Улаанбаатар хот, 17130
 Утас: (976) 111 32 80
 Цэвэр хуудас: www.ais.gov.mn

2026.06.05 № 05/3693


Саяал хургуулах тухай

Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Нийслэлд хэрэгжсэн автозам, бродерын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд" танилцаж.

Тайлангийн төсөлд дурдсан зөвхөн дүнчилтэй холбоотуулан захиалгыг захиалгачийн амжилтын байгууллагаас гаргах буй тайлбар, саналыг хянахтай хургуулах байна.

Тайлбар, саналтай танилцаж, тайлангийн төслийн холбогдох хэсэгт саналыг тусган, өөрчлөлт оруулж өгөхийг хувиар.

Хавсралт 6 хуудастай

ДАРГА  Т.СЮУНИМӨГ



Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын даргын 2026 оны 05 дугаар 05/3693 тоот тушаал

"НИЙСЛЭЛД ХЭРЭГЖСЭН АВТОЗАМ, БРОДЕРЫН ШИНЭЧЛЭЛТЭЙ ХОЛБООТой ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ХҮРГУУЛЖ БАЙГАА ТАЙЛБАР, САНАЛ

Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Нийслэлд хэрэгжсэн автозам, бродерын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд" 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 1089 дугаартай албан ёсоор ирүүлсэнгэй танилцаж, дараах хариуг хүргүүлж байна.

Дор дурдсан тайлбар, саналтай танилцаж, тайлангийн төслийн холбогдох хэсэгт саналыг тусган, өөрчлөлт оруулж өгөх үү.

1. Авто замын засвар ажилчлалтын 5 төсөл арга хэмжээнд 14,288.1 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг урьдчилгаа төлбөрийн баталгаажуулгаар олгохын тухай.

Тайлбар: Төслийн зарчмыг оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд урьдчилгаа санхүүжилт олгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн зарчмыг оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлж, ажил, үйлчилгээг үргэлж", Сэлбэгийн сайдын 2023 оны 252 дугаар тушаалын хяналтаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болж хураах" а заалмы дагуу урьдчилгаа төлбөрийг баталгаажуулж үндэслэн олгох байна.

Тайлангийн төсөлд дурдсан авто замын засвар ажилчлалтын 5 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.8 даяа хэсэгт "Зөвхөн хүчээр нэгтгэн, ажил, үйлчилгээний, онцгой байдалын байгууллага, цагдаа, дотоодын цэргийн, хэрэг байгууллагын тусгай хэрэгжүүлэх болон нийслэл хотын аж ахуй, өмчлөх зориулалтын бараа, ажил, үйлчилгээг тусгай санхүүгээр төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн төслөөр үйлдвэрлэл, газар гүйцэтгүүлж, хэсэг зарлыг байгууллагын зарын хэрэгжүүлэх ажилыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлж нь үр ажилтай гэж захиалгыг үзсэн бол захиалгач төлбөр шалгаруулалтын аргыг хэрэглэж байх байна" гэж заалмы дагуу орон нутгийн өмчийн аж ахуйн төслөөр үйлдвэрлэл, газар Улаанбаатар зам засвар, арчлалтын газартай хувиар гэрээ байгуулсан.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ
 Нийслэлчин аяа 1200, Аудитын өм, 25 дугаар хороо, 3-ын 7-ий дугаар, Улаанбаатар хот, 17130
 Утас: (976) 111 32 80
 Цэвэр хуудас: www.ais.gov.mn

2026.06.05 № 02/298

Баримт бичиг хүргүүлэх тухай

Нийслэл дэх Төрийн аудитын газраас "Нийслэлд хэрэгжсэн авто зам, бродерын шинэчлэлтэй холбоотуулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд" 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 05-03/0574 дугаартай албан ёсоор ирүүлж дагуу авто замын зураг төсөл, холбогдох материалыг нэрд дэсгэнд хуульчлалтын хургуулах байна. Баримт: 15805 хуудастай

Замны нэгдлийн гэмэр
 Хэрэгжүүлэгч
 Газрын даргын ажил үүргийг гүйцэтгэх
 Баталгач Оффисер
 2026.06.05 15:12



"УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ГАЗАР" ОНБААЛУТ
 Улаанбаатар хотын төв, 14 дугаар хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 17130
 Утас: (976) 111 42 20 20, 2020 (976) 111 42 20 20
 Цэвэр хуудас: www.ons.gov.mn
 Цэвэр хуудас: www.ons.gov.mn

2026.06.05 № 170

Тайлбар, санал хүргүүлэх тухай

Манай газарт ирүүлсэн "Нийслэлд хэрэгжсэн автозам, бродерын шинэчлэлтэй холбоотой төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2025/42-ШТАГА) тайлан"-тай танилцаж тайлангийн 2.12 дугаар хэсэгт тайлбар хүргүүлж байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/1461 "Их үүрэг шилжүүлэх тухай" захираж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/293 "Их үүрэг шилжүүлэх ажилыг хэсэг байгуулах тухай" тушаал гарсантай холбоотуулан нийт 45 машин механизм 22 машин механизм" "Баруун бүсийн зам засвар арчлалтын газар" ОНБААЛУТ-г шилжүүлэн өгсөн.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/783 дугаар захирамжаар 4 төсөл арга хэмжээг дүрмээр нутгасын нэг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлэхээр эрх шилжжээ. Тус 4 байршилны баруун аймаг салдаг уулуурын зам маш их явдалтай мөн. Үндэсний Их бар нэгдлийн зам тус 4 төсөл арга хэмжээг хийж хэрэгжүүлж шалдлагатай байсан бөгөөд манай байгууллага өөрсдийн нийц бодолцоогоор богино хугацаанд гүйцэтгэх боломжгүй болсон тул дээд газрын санхүүг дагуу Мегатитан ХХК, Тотал инж. ХХК-уудтай туслан гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн А/1064 дугаар захирамжаар "Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Биевэл дүүрэг, 20 дугаар хороо)"-ны ажлыг хэрэгжүүлэхээр эрх шилжжээ. 2024 оны 09 дугаар сарын 18-наас Наваргад авто замын Эрчим хүчний гудамжтай холбох шинэ гүүр ашиглахад орсонтой холбоотойгоор тус ажлыг эрчимжүүлэн гүйцэтгэх шалдлагатай болсон. Тус ажил нь 6 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил мөн холбоо, дулаан цахилгаан гэх мэт инженерийн шугам сүлжээний ажлуудыг манай газар нь байгаа машин механизм, хүч хүч нийц бодолцоогоор 2 жил дамаж гүйцэтгэх хэмжээний том ажил байсан тул мөн дээд газрын санхүүг дагуу туслан гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажилласан болно.

Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНБААЛУТ
 Хэрэгжүүлэгч
 Газрын дарга
 Төрийн үйлчилгээ
 2026.06.05 16:18

Саналд өгсөн тайлбар

ИРҮҮЛСЭН САНАЛ	САНАЛЫГ ХҮЛЭЭН АВСАН ЭСЭХ	НТАГ-ЫН ТАЙЛБАР
Нийслэлийн ЗДТГ-ын 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 03/3693 дугаартай албан бичиг		
1	Үгүй	ТАХ-д урьдчилгаа санхүүжилтийг олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12.2.-д “урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх (Сангийн сайдын тушаалаар баталсан “Урьдчилгаа төлбөрийн баталгаа болон даатгалын маягт”-ын дагуу гаргана);” гэж заасныг баримтлах нь зүйтэй учир тайлангийн төслөөс хасах шаардлагагүй гэж үзлээ. Дээрх зөрчилд өгч буй аудитын шийдвэр давхардсан тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.
2	Үгүй	ТАХ-ний магадлалын ерөнхий дүгнэлтийн батлагдсан огноог үндэслэсэн учир тайлангийн төслөөс хасах шаардлагагүй гэж үзлээ.
3	Үгүй	Аудитын гүйцэтгэлийн үе шатанд нотлох баримт ирүүлээгүй тул тайлангийн төслөөс хасах шаардлагагүй гэж үзлээ.
4	Үгүй	Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд тусгасан шаардлагыг баримтлах нь зүйтэй учир тайлангийн төслөөс хасах шаардлагагүй гэж үзлээ.
5	Тийм	Саналыг хүлээн авч тайлангийн төслийн холбогдох хэсэгт өөрчлөлт орууллаа.
“Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-ын 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 170 дугаартай албан бичиг		
1	Үгүй	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г хэрэгжүүлэхдээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөх нь зүйтэй учир тайлангийн төслөөс хасах шаардлагагүй гэж үзлээ.

Хавсралт.1 Зураг, төсөвт магадлалыг захирамж гарсны дараа баталгаажуулсан ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	НЗД-ын захирамж		МЭД		(сая.төг) Төсөвт өртөг
		Огноо	Батлагдсан төсөвт өртөг	Огноо	Төсөвт өртөг	
1	Богд уулын арын авто замын засвар, шинэчлэлт. (Буган халиунаас Маршалын гүүр)	2024.06.20	1,274.0	2024.07.09	1,274.0	0.0
2	Чингэлтэйн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (32-ын уулзвараас Хайлаастын уулзвар)	2024.06.20	2,131.5	2024.07.09	2,131.5	0.0
3	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Гэсэр сүмийн уулзвараас Дөлгөөн нуурын уулзвар хүртэл, хойд хэсэг)	2024.07.08	2,700.0	2024.12.06	2,728.2	(28.2)
4	Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Хил хамгаалахын ерөнхий газрын хойд уулзвар)	2024.06.20	1,872.0	2024.07.09	1,869.7	2.3
5	Ард Аюушийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Гэмтлийн уулзвар)	2024.06.20	1,521.0	2024.07.09	1,521.0	0.0
6	Элчингийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Шангрилагийн уулзвараас Парисийн гудамж хүртэл)	2024.07.08	1,155.0	2024.09.25	1,155.6	(0.6)
7	Чагдаржавын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Энхтайваны өргөн чөлөөнөөс урагш Элчингийн гудамж хүртэл)	2024.07.08	600.0	2024.09.25	601.1	(1.1)
8	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Төмөр замын гарамын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	2024.07.08	5,985.0	2024.09.06	6,277.4	(292.4)
9	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	2024.07.08	6,300.0	2024.09.06	6,558.1	(258.1)
10	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	2024.07.08	8,375.0	2024.09.06	8,716.9	(341.9)
11	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг)	2024.07.08	8,950.0	2024.09.06	9,377.3	(427.3)
12	Галданбошготын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (32-ын уулзвараас Баянбүрдийн тойрог Чингэлтэй дүүрэг)	2024.06.20	3,570.0	2024.07.09	3,570.0	0.0
13	Цагдаагийн академийн өргөн чөлөөний авто замын засвар, шинэчлэлт (Офицеруудын ордны тойргоос Ботаникийн уулзвар)	2024.06.20	5,527.2	2024.07.09	5,527.2	0.0
14	Чингүнжавын гудамжны авто зам засвар, шинэчлэлт (Өргөө кино театрын уулзвараас 25-р эмийн сангийн уулзвар)	2024.06.20	2,815.5	2024.07.09	2,815.5	0.0
15	Нарны замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Энхтайваны гүүрнээс 10-р хорооллын уулзвар)	2024.06.20	9,450.0	2024.07.19	9,811.3	(361.3)
16	Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Маршалын гүүрнээс Баянзүрхийн гүүр Баянзүрх дүүрэг)	2024.06.20	9,464.0	2024.07.19	9,464.0	0.0
17	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас ТЭЦ-3-ийн уулзвар Хан-Уул дүүрэг)	2024.06.20	7,800.0	2024.07.09	7,779.8	20.2
18	Нийслэл хүрээний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (120-ын тэмээтэй хөшөөний уулзвараас зүүн тийш И-Мартын уулзвар Хан-Уул дүүрэг)	2024.06.20	7,392.0	2024.07.09	7,824.9	(432.9)
19	Үндсэн хуулийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Баруун 4 замын уулзвараас Нарны зам)	2024.06.20	1,861.8	2024.07.19	1,861.8	0.0
20	Нарны замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өгөөмөр захаас Чулуун овооны тойрог)	2024.06.20	4,680.0	2024.07.19	4,680.0	0.0
21	Наадамчдын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Яармагийн гүүрнээс Нүхтийн уулзвар)	2024.06.20	5,775.0	2024.07.19	5,998.7	(223.7)
22	Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан)	2024.06.20	21,813.3	2024.12.25	15,291.6	6,521.0
23	Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Энхтайваны гүүрнээс дунд голын гудамж, Тэмээтэй хөшөө) -ийн ажил	2024.06.20	2,903.7	2024.07.09	2,903.6	0.1
24	Олимпын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Гадаад хэргийн яамны уулзвараас Олимпын гүүр)	2024.06.20	1,725.5	2024.07.19	1,725.5	0.0
25	Архивчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт, (Нисэхийн тойргоос нисэхийн хурдны зам)	2024.06.20	9,800.0	2024.07.09	9,813.2	(13.2)
26	Их монгол улсын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Хоум плазагаас урагш Их тэнгэрийн уулзвар хүртэл)	2024.07.08	5,148.5	2024.10.01	4,987.9	160.6
27	Зайсангийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (120 мянгатын уулзвараас Зайсангийн гүүр)	2024.06.20	4,275.0	2024.07.09	4,275.0	0.0
28	Ажилчны гудамжны авто замын засвар шинэчлэлт. (Саппорогийн уулзвараас Чингисийн өргөн чөлөө)	2024.06.20	6,930.0	2024.07.09	6,930.0	0.0
29	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баруун 4 замаас- Гэсэр сүмийн уулзвар)	2024.06.20	2,499.0	2024.07.25	2,497.7	1.3
30	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Өлзий төвийн уулзвараас 100 айлын уулзвар хүртэл)	2024.06.20	2,146.0	2024.07.25	2,144.9	1.1
31	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (100-н айлын уулзвараас Сансарын аюулгүйн тойрог)	2024.06.20	3,381.0	2024.07.25	3,388.5	(7.5)
32	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Сансарын аюулгүйн тойргоос Зүүн 4-н зам)	2024.06.20	1,680.0	2024.07.25	1,675.3	4.7
33	Чингэлтэйн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (7-н буудлын эцсээс Дамбын пост)	2024.06.20	1,310.4	2024.07.09	1,312.2	(1.8)
34	Шархадны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Цайз захын уулзвараас Эрдэнэтөлгойн уулзвар)	2024.06.20	3,094.0	2024.07.09	3,094.0	0.0
35	Их нарангийн авто замын засвар, шинэчлэлт. (Толгойтын авто замаас Улаан чулуутын хогийг цэг)	2024.06.20	2,566.2	2024.07.09	2,566.2	0.0
36	СХД-ийн 4, 5 дугаар хорооны далан дагасан авто замын засвар, шинэчлэлт. (Толгойтын замаас далан дагаад Баянхошууны зам)	2024.06.20	2,541.9	2024.07.09	2,541.9	0.0
37	Хүннүгийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Хоум Плазгагийн уулзвараас Дунжингарав худалдааны төвийн уулзвар хүртэл)	2024.07.08	2,310.0	2024.09.06	2,310.4	(0.4)
38	Улаанхуарангийн авто замын засвар, шинэчлэлт. (Офицеруудын ордны тойргоос Шар хадны авто зам хүртэл)	2024.07.08	3,360.0	2024.09.06	3,360.1	(0.1)
39	Дандарбаатарын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Офицеруудын ордны тойргоос Цайз захын уулзвар хүртэл)	2024.07.08	1,620.0	2024.10.01	1,565.2	54.8
40	Тангангийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Чингисийн өргөн чөлөөнөөс Дунд голын авто зам хүртэл)	2024.07.08	525.0	2024.10.01	525.0	0.0
41	Городокын авто замын засвар, шинэчлэлт (Налайх дүүрэг, 5 хороо, Төв замаас Городок хүртэл Налайх дүүрэг)	2024.07.08	1,155.0	2024.10.01	1,098.7	56.3
42	Багахангай дүүргийн 1, 2 дугаар хорооны авто замын засвар, шинэчлэлт (Багахангай дүүрэг)	2024.07.08	1,515.3	2024.10.01	1,515.3	0.0
43	Багануур дүүргийн авто замын засвар, шинэчлэлт (Багануур дүүрэг)	2024.07.08	720.0	2024.07.31	752.7	(32.7)
44	Дүнжингарав худалдааны төвийн урд талын авто замын засвар, шинэчлэлтийн өргөтгөл (Баянзүрх дүүрэг)	2024.07.08	1,700.0	2024.07.16	1,658.4	41.6
45	Хайлаастын гудамжны авто замын засвар, шинэчлэлт. (Чингэлтэйн өргөн чөлөөнөөс Хайлаастын эцэс хүртэл Чингэлтэй дүүрэг)	2024.07.08	4,200.0	2024.08.23	4,200.0	0.0

46	Дарь-Эхийн авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын колонкийн уулзвараас Дамбадаржаагийн уулзвар хүртэл Баянзүрх дүүрэг)	2024.07.08	6,930.0	-	-	-
47	Дамбадаржаа-Шадивлангийн авто замын засвар, шинэчлэлт. (Дамбадаржаагийн замаас Шадивлангийн зуслан хүртэл Сүхбаатар дүүрэг)	2024.07.08	5,218.5	2024.08.19	5,218.4	0.1
48	Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Наадамчдын замаас Нүхтийн ам чиглэлийн авто зам (Хан-Уул дүүрэг)	2024.07.08	3,397.5	2023.11.13	3,662.8	(265.3)
49	Худгийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Авто плазагийн уулзвараас Хангай хотхоны уулзвар хүртэл Сүхбаатар дүүрэг)	2024.07.08	700.0	2024.10.18	771.7	(71.7)
50	Сансарын туннелийн авто замын засвар, шинэчлэлт. (И мартын уулзвараас туннель доогуур Их тойруу хүртэл Баянзүрх дүүрэг)	2024.07.08	1,050.0	2024.09.06	1,050.6	(0.6)
51	Натурын авто замын засвар, шинэчлэлт (Дамдинсүрэнгийн гудамжнаас урагш Нарны зам хүртэл)	2024.07.08	630.0	2024.09.25	633.3	(3.3)
52	Сангийн хорооны гудамжны авто замын шинэчлэл (Бөхийн өргөөний уулзвараас Натурын зам)	2024.07.08	1,308.0	2024.09.25	1,320.3	(12.3)
53	Халдвартын эцсийн авто замын засвар, шинэчлэлт (Намьянжугийн гудамжнаас зүүн тийш халдвартын эцэс хүртэл)	2024.07.08	1,132.5	2024.10.01	1,081.3	51.2
54	Хонхны гудамжны засвар, шинэчлэлт (Энхтайваны өргөн чөлөө, Төмөр замын уулзвараас Өгөөжийн уулзварын зүүн тал хүртэл)	2024.07.08	1,680.0	2024.11.19	1,636.0	44.0
55	СХД, 9 хороо, амбулаторийн авто зам	2024.07.08	458.0	2024.03.04	286.2	171.8
56	Сансарын туслах авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын шатахуун түгээх станцаас Зүүн 4 зам хүртэл зорчих хэсгийн баруун тал)	2024.07.08	1,080.0	2024.12.06	1,003.8	76.2
57	Лувсанцэвээний гудамж авто замын засвар, шинэчлэлт (Энхтайвны өргөн чөлөөнөөс Кино үйлдвэр баруун талаар Доржийн гудамж хүртэл)	2024.07.08	840.0	2024.07.31	840.7	(0.7)
58	Баруун үйлдвэрийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Хөсөг трейдийн уулзвараас зүүн тийш фризерийн зүүн тал хүртэл)	2024.07.08	1,260.0	2024.11.01	1,260.1	(0.1)
59	СХД 32-р хороо, Хурганы зам (Эмээлтийн авто замаас шинэ цэцэрлэг хүртэл)	2024.07.08	4,500.0	2024.09.06	4,509.9	(9.9)
60	Сүхбаатар дүүрэг 9, 11-р хороо Алтайн гудамжнаас Галданбошигтын гудамж хүртэл 7-р хорооллын шинэ гол гудамж зам	2024.07.08	4,700.0	2024.09.06	2,435.2	2,264.8
61	Энхтайваны өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (25 дугаар эмийн сангийн уулзвараас зүүн 4 замын уулзвар)	2024.06.20	18,200.0	2024.07.09	18,201.3	(1.3)
62	Алтан-Овооны замын уулзвараас Найрамдлын зам хүртэлх	2024.07.08	7,500.0	-	-	-
63	СХД, 129 дүгээр сургуулийн авто замын үргэлжлэл (Сонгионхайрхан дүүрэг)	2024.07.08	560.0	2024.09.19	475.5	84.5
64	Гүнтийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Шаргаморьтын уулзвараас Гүнтийн даваа хүртэл Чингэлтэй дүүрэг)	2024.07.08	5,250.0	2024.07.09	4,114.0	1,136.0
65	Доржийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Хил хамгаалах ерөнхий газрын хойд уулзвараас Цайз захын уулзвар)	2024.07.08	5,670.0	2024.08.19	5,669.9	0.1
	Нийт		260,183.3		226,863.3	33,320.0

Хавсралт. 2 Магадлалын дүгнэлт баталгаажуулах байхад ажлыг эхлүүлэх, зөвшөөрөл олгосон ТАХ-ний жагсаалт

- Орбитын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Сонгинохайрхан дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр гарсан;
- Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Хан-Уул дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр гарсан;
- Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Сүхбаатар дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр гарсан;
- Хатанбаатар Магсаржавын гудамжны авто замын засвар, шинэчлэлт /Баянгол дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 202 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр гарсан;
- Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр гарсан;
- Хилчний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр гарсан;
- Хувьсгалчдын гудамжны авто замын засвар, шинэчлэлт /Тасганы овооны уулзвараас Зурагтын эцэс хүртэл/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 09 дүгээр сарын 04-нд гарсан;
- Дүнжингарав худалдааны төвийн урд талын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 16-нд гарсан;
- Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг, Соёолжийн нүхэн гарц орчмоос Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвар чиглэл/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр гарсан;
- Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг, Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвараас Өгөөмөр зах чиглэл/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр гарсан;
- Намьянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Баянзүрх дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр гарсан;

- Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Дөлгөөн нуурын уулзвараас Өлзий төвийн уулзвар хүртэл/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр гарсан;
- 22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт. (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл Сонгинохайрхан дүүрэг) ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр баталгаажсан боловч ажил эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гарсан;
- Дарь-Эхийн авто замын засвар, шинэчлэлт. (Сансарын колонкийн уулзвараас Дамбадаржаагийн уулзвар хүртэл Баянзүрх дүүрэг) ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт гараагүй байхад ажил эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр гарсан;
- Худгийн гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Авто плазагийн уулзвараас Хангай хотхоны уулзвар хүртэл Сүхбаатар дүүрэг) ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталгаажсан боловч ажил эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр гарсан;
- Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт /Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг/ ажлын төсөвт өртгийн магадлалын дүгнэлт 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр баталгаажсан боловч ажлыг эхлүүлэх зөвшөөрөл 2024 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр гарсан байна.

Хавсралт.3 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	НЗД-ын захирамж		МЕД		(сая.төг)
		Огноо	төсөвт өртөг	Огноо	Төсөвт өртөг	Төсөвт өртгийн зөрүү
1	Эрчим хүчний гудамжны авто замын өргөтгөл, их засварын ажил (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо)	2024.03.15	18,479.9	2024.05.09	14,665.8	3,814.1
2	Сонгинохайрхан дүүргийн 1 дүгээр хороо, 107 дугаар сургууль орчмын авто зам, зогсоолын ажил (СХД 1 дүгээр хороо)	2024.03.15	291.4	2023.11.13	224.5	66.9
3	Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хороонд шинээр баригдах авто зам (СХД 2 дугаар хороо)	2024.03.15	1,384.8	2023.12.05	1,118.5	266.3
4	Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хороонд шинээр баригдах авто зам (СХД 3 дугаар хороо)	2024.03.15	1,027.5	2023.06.21	829.9	197.6
5	Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хороонд шинээр баригдах авто зам (СХД 22 дугаар хороо)	2024.03.15	2,093.9	2023.12.08	1,952.4	141.5
6	Сонгинохайрхан дүүргийн 24 дүгээр хороонд шинээр баригдах авто зам (СХД 24 дүгээр хороо)	2024.03.15	1,304.8	2023.12.05	930.0	374.8
7	34 дүгээр байрны ард баригдах гүүрийн ажил (СХД 30 дугаар хороо)	2024.03.15	1,784.1	2023.11.27	1,667.0	117.1
8	Сонгинохайрхан дүүргийн 36 дугаар хороонд шинээр баригдах авто зам (СХД 36 дугаар хороо)	2024.03.15	1,820.5	2023.12.28	1,530.9	289.6
9	Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо, 124 дүгээр сургуулийн урд талаар шинээр баригдах авто зам (СХД 41 дүгээр хороо)	2024.03.15	2,639.5	2023.12.11	2,269.3	370.2
10	Хайрханы 17 дугаар гудамжнаас шинээр баригдах цэцэрлэг хүртэлх авто зам (СХД 42 дугаар хороо)	2024.03.15	1,374.6	2023.08.24	1,188.4	186.2
	Нийт		32,201.0		26,376.7	5,824.3

Хавсралт.4 Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний жагсаалт

№	ТАХ-ний нэр	НЗД-ын захирамж		МЕД		(сая.төг)
		Огноо	төсөвт өртөг	Огноо	Төсөвт өртөг	Төсөвт өртгийн зөрүү
1	Амгалангийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2024.01.12	4,750.0	2024.05.09	4,497.0	253.0
2	Дүнжингарав худалдааны төвийн урд талын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2024.01.12	1,690.0	2024.07.16	1,658.5	31.5
3	УБЦТС-ын баруун талын авто замын засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)	2024.01.12	850.0	2024.06.20	793.8	56.2
4	Хилчний гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2024.01.12	820.0	2024.06.20	810.5	9.5
5	Орбитын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сонгинохайрхан дүүрэг)	2024.01.12	2,890.0	2024.06.20	2,571.4	318.6
6	Богд уулын арын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Хан-Уул дүүрэг)	2024.01.12	1,200.0	2024.05.24	1,139.7	60.3
7	Намьянжугийн гудамжны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2024.01.12	3,125.0	2024.05.24	2,991.2	133.8
8	Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг)	2024.01.12	3,700.0	2024.06.20	3,705.8	(5.8)
9	Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Соёолжийн нүхэн гарц орчмоос Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвар чиглэл)	2024.01.12	2,350.0	2024.05.24	2,245.5	104.5
10	Нийслэл хүрээ өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг)	2024.01.12	3,530.0	2024.05.24	3,320.8	209.2
11	Нэгдсэн үндэстний гудамжны авто замын хэсэгчилсэн авто замын засвар, шинэчлэлт (Сүхбаатар дүүрэг)	2024.01.12	560.0	2023.11.07	292.3	267.7
12	Хатанбаатар Магсаржавын гудамжны авто замын засвар, шинэчлэлт (Баянгол дүүрэг)	2024.01.12	800.0	2024.07.02	766.1	33.9

13	Нарны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Баянзүрх дүүрэг, Нарантуул олон улсын худалдааны төвийн уулзвараас Өгөөмөр зах чиглэл)	2024.01.12	1,880.0	2024.06.20	1,833.5	46.5
14	Богд уулын арын авто замын баруун хэсгийн засвар шинэчлэлт	2024.03.26	2,613.0	2024.06.20	2,555.0	58.0
15	Их тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар шинэчлэлт (Дөлгөөн нуурын уулзвараас Өлзий төвийн уулзвар хүртэл)	2024.03.26	1,248.0	2024.10.03	1,170.3	77.7
16	Хувьсгалчдын гудамжны авто замын засвар шинэчлэлт (Тасганы овооны уулзвараас Зурагтын эцэс хүртэлх)	2024.03.26	3,800.5	2024.09.06	3,765.9	34.6
Нийт			35,806.5		34,117.3	1,689.2